

И. И хх хг и гх.

**АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ТАНДАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ

2025 он

**АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ТАНДАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

Нэг.Асуудалд дүн шинжилгээ хийсэн байдал

Хоёр.Асуудлыг шийдвэрлэх зорилгыг тодорхойлсон байдал /олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалттай харьцуулсан байдал/

Гурав.Асуудлыг зохицуулах хувилбарууд, эерэг, сөрөг үр дагаварт хийсэн харьцуулалт /үр дүнтэй хувилбарын тухай/

Дөрөв.Сонгосон хувилбарын үр нөлөөг тандан судалсан байдал

- хүний эрхэд үзүүлэх үр нөлөө
- эдийн засагт үзүүлэх үр нөлөө
- нийгэмд үзүүлэх үр нөлөө
- байгаль орчинд үзүүлэх үр нөлөө
- Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

Тав.Зөвлөмж, дүгнэлт

Хавсралт

- хүний эрхэд үзүүлэх үр нөлөө
- эдийн засагт үзүүлэх үр нөлөө
- нийгэмд үзүүлэх үр нөлөө
- байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

НЭГ.АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Дэлхий дахинаа цахим спортын төрөл маш хурдацтай хөгжиж зах зээлийн нэгэн томоохон орон зай болно гэдэг нь тодорхой болжээ. Энэ төрлийн спорт нь 1970-1980 онд видео тоглоом гарч ирснээс улбаатай бөгөөд цахим тоглоомын анхны хүлээн зөвшөөрөгдсөн арга хэмжээ 1972 онд Стэнфордын их сургууль дээр зохион байгуулагдаж, улмаар 1980 онд АНУ-д /Атари/ 10 мянган оролцогчтой зохион байгуулагдсан нь анхны томоохон тэмцээн болж байсан түүхтэй.

Тэр цаг үеэс эхлэн өнөөдрийг хүртэл хөгжихдөө дэлхий даяар мэргэжлийн лигүүд байгуулагдаж, үзэгч, дэмжигчийн тоо тэр бумаар тоологдож, шагналын сан асар өндөр дүнд хүрч, 2022 оны Азийн наадмын спортын хөтөлбөрт багтжээ.

Дэлхийн бусад орнууд и-спортыг спортын төрөлд хамааруулж альхэдийн тусгайлан анхаарч эхлээд байна. Энэ төрөл нь өмнө дурдсанчлан Азийн наадмын төрөлд шинээр нэмэгдэж эхэлсэн төдийгүй одоогоор олимпын төрөлд хараахан багтаагүй боловч Олон улсын олимпийн хороо (IOC) албан ёсоор анхны Олимпийн eSports Наадам (OEG)-ыг 2027 онд Саудын Арабын Эр-Рияд хотод зохион байгуулахаа баталгаажуулаад байна. Ийнхүү энэ төрлийн спорт дэлхий даяар хүлээн зөвшөөрөгдөж, олимпын наадмын хөтөлбөрт багтахад нэгэнт ойрхон болжээ.

Багийн спортын төрөлд хөгжил багатай манай улсын хувьд цахим спортоор дэлхийн бусад улсуудтай харьцангуй жигд гараанаас эхэлсэн тул энэ төрлийн тамирчид азидаа төдийгүй дэлхийд өндөр амжилт үзүүлсээр байна. 2025 оны 8 дугаар сард Саудын Арабын Эр-Рияд хотноо 16 баг оролцсон, 1,250,000 ам.долларын шагналын сан бүхий “Esport World Cup 2025” дэлхийн цомын тэмцээний “Counter Strike 2” төрөлд манай улсын “The Mongolzs” баг аварга болж, тоглогч М.Содбаяр /Techno 4k/ үнэ цэнэтэй тоглогчоор шалгарсан нь Монголын тамирчдын чадварыг харуулж байна. Түүнчлэн 2024 онд болсон и-спортын Pubg mobile төрлийн дэлхийн аваргын тэмцээнд манай улсын 3 баг I, II, IV байранд шалгарч байсан удаатай. Ийнхүү И-спортыг дэлхийн улс орнуудтай энэ үед мөр зэрэгцэн хөгжүүлэх боломж бидэнд байна.

Түүнчлэн цахим спортыг дагаад спонсоршипын хэлхээ явж байдаг учраас амжилттай байх тусам томоохон компаниуд хөрөнгө оруулж, ивээн тэтгэж, хамтран ажиллаж олон боломжуудыг эрэлхийлж байдаг. Нөгөө талаас спонсоршип, цалин, стрийм, хандив, нэмэлт орлого, рекламны орлого, шагналын сан зэрэг мэргэжлийн тамирчдын хувьд орлогын олон эх үүсвэр байдаг боловч манай улсад энэ боломжууд одоогоор бүрэн утгаараа ажиллаж чадахгүй байгаа учраас тамирчид гадаадын тамирчдын адил боломжийг эдлэх боломжгүй байна

Манай улсын хувьд спортын хөгжлийг авч үзэхдээ олимпын болон үндэсний гэсэн төрөлд хамааруулж, түүнд үндэслэн дэмжлэг урамшуулал, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг зохицуулж ирсэн.

Түүнчлэн Улсын Их Хурлаас 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдөр Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт оруулж соёл, спортын байгууллагад ажиллах гадаадын мэргэжлийн багш, дасгалжуулагчийг авч ажиллуулах ажил олгогчийг ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх зохицуулалтыг бий болгосон. Энэхүү ажлын байрны төлбөрөөс чөлөөлөхөд спортын төрлийг тусгайлан заагаагүй нь сайшаалтай.

Биеийн тамир, спортын тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай зэрэг хуулиудаар спорт дахь урамшуулал, дэмжлэг, татварын хөнгөлөлтийн талаар зохицуулж байна.

Эдгээр хуулийг үндэслэн эрх бүхий этгээдийн баталсан шийдвэрүүд ч олимпын болон үндэсний спортыг дэмжихэд чиглэжээ. Тухайлбал, Засгийн газрын 2018 оны 173 дугаар тогтоолоор баталсан “Олон улсын олимпийн хорооны ивээл дор зохион байгуулагддаг тив, дэлхийн наадам болон дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчийг шагнаж урамшуулах, мөнгөн шагнал олгох журам”, “Үндэсний хэмжээний тэмцээн, наадамд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчийг шагнаж урамшуулах, мөнгөн шагнал олгох журам”, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн А/175 дугаар тушаалаар баталсан спортын барилга байгууламж барьж байгуулах, олимпын төрлийн тэмцээн зохион байгуулах, Монголын үндэсний олимпын хороо, Монгол үндэсний паралимпын хорооны бүртгэлтэй олимпын төрлийн спортын холбоо, түүнд бүртгэлтэй баг, мэргэжлийн тамирчин, дасгалжуулагчид олгосон санхүүгийн дэмжлэгийн хүрээнд албан татварын хөнгөлөлтөд хамрагдах бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага.¹ зэрэг шийдвэрүүд байна.

Шинэ тутамд эрчимтэй хөгжиж байгаа, ирээдүйд амжилт үзүүлэх боломжтой гэж үзэж болох и-спортын төрөл нь олимпын төрөлд хараахан багтаагүй байх тул дээрх татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдахгүй байгаад анхаарч тусгайлан спортын энэ төрлийг мөн адил хамруулах зохицуулалтыг бий болгох нь зүйтэй байна.

¹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17431391348732&showType=1>

Иймд манай улс олимпын наадмын хөтөлбөрт багтдаг спортын төрлийг хөгжүүлэхээс гадна багийн спортыг хөгжүүлэх, шинэ тутам гарч ирж байгаа спортын төрлийг одооноос дэмжих, эдгээр төрөлд хүний нөөц бэлтгэх, амжилт гаргах боломжийг нэмэгдүүлэхэд одооноос төрөөс эрх зүйн орчинг бүрдүүлэх замаар дэмжлэг үзүүлэх шаардлагатай байдаг.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны бодлого”-ын 3.5.13-т биеийн тамир, спортын нэн шаардлагатай болон тэргүүлэх чиглэл, мэргэжлээр хүний нөөц бэлтгэх арга хэмжээг хэрэгжүүлэхээр заасан байдаг.

Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталж 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр дагаж мөрдөж буй Биеийн тамир спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтад Улсын Их Хурал биеийн тамир, спортын талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлохоор гэж заасан.

Биеийн тамир, спортын тухай хуулийн дагуу тухайн төрлийн спортын холбооны саналаар Үндэсний шигшээ баг бүрдүүлэн биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулан ажиллах боломж нээлттэй байдаг.

№	Спорт холбоо	2021	2022	2023	2024		
					ОУТ, бэлтгэл цугларалт	Хэрэглэл материал	Нийт төсөв
1	Пара буудлага	138,600,000	60,000,000	130,135,607	288,400,000	60,000,000	348,400,000
2	Пара жүдо	251,000,000	112,000,000	213,815,398	573,000,000	20,000,000	593,000,000
3	Пара таеквондо	258,000,000	81,670,000	334,698,068	542,000,000		
4	Пара хөнгөн атлетик	202,400,000	47,806,000	182,763,777	521,600,000		
5	Пара Бочи	-	-	71,899,988	197,400,000		
6	Пара уулын цана	-	38,085,900	102,848,210	220,000,000		
7	Пара гүйлтийн цана	126,330,000	256,332,800	101,994,268	344,500,000	30,000,000	374,500,000
8	Пауэрлифтинг	84,760,000	105,000,000	161,455,477	394,800,000	70,000,000	464,800,000
9	Пара байт харваа	266,690,000	84,708,000	211,808,178	496,800,000	60,000,000	
10	Ширээний теннис	190,000,000	58,500,000	182,042,818	393,000,000		
11	Жүдо	947,000,000	345,000,000	1,069,691,933	1,744,000,000	220,000,000	1,964,000,000
12	Бокс	592,000,000	310,000,000	1,120,875,335	1,364,000,000	80,000,000	1,444,000,000
13	Гимнастик	90,000,000	28,000,000	123,220,284	478,200,000		
14	Хөнгөн атлетик	129,500,000	85,000,000	185,518,455	369,300,000		
15	Таеквондо	263,800,000	115,000,000	248,893,428	563,000,000		
16	Шатар	70,000,000	35,000,000	117,490,506	407,800,000		
17	Хүндийн өргөлт	269,000,000	155,000,000	438,950,911	946,129,500	180,000,000	1,126,129,500
18	Цана	254,364,000	514,193,500	393,878,945	740,000,000	60,000,000	800,000,000
19	Тэшүүр	215,000,000	68,042,800	125,617,584	426,100,000	20,000,000	446,100,000
20	Биатлон	285,000,000	376,970,100	365,172,488	826,500,000	80,000,000	906,500,000
21	3х3 Сагсан бөмбөг	260,000,000	150,000,000	272,000,000	911,870,000		
22	Буудлага	200,800,000	67,000,000	891,208,933	973,900,000	390,000,000	1,363,900,000
23	Чөлөөт бөх	961,000,000	387,028,000	876,586,515	1,578,000,000	220,000,000	1,798,000,000
24	Байт харваа	264,981,000	103,344,000	227,165,253	668,200,000	80,000,000	748,200,000
25	Дугуй	-	30,733,600	122,645,213	469,500,000		
Нийт		6,320,227,021	3,614,416,722	8,272,379,595	16,437,999,500	1,570,000,000	18,007,999,500

2021-2024 онд спортын холбоодод улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлсэн тухай мэдээлэл²

Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтын дагуу улсын төсвөөс дэмжлэг үзүүлэх спортын төрлийн ангиллыг сонгох, үндэсний шигшээ багийг бүрдүүлэх үүднээс Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын 2025 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн “Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх тухай А/82 дугаар тушаалаар 26 спортын төрлийн жагсаалт, орон тооны хязгаарыг баталж, холбогдох журмын хүрээнд спортын холбоодтой гэрээ байгуулан санхүүжүүлж байна. Үүний дагуу спортын 26 төрлөөр үндэсний шигшээ баг бүрдүүлэн 250 тамирчин, 4 эмч, 60 дасгалжуулагч нийт 31 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Эдгээр 28 спортын төрлөөс шатар болон и-спортын төрөл нь олимпын бус үндэсний шигшээ багийн төрөл бөгөөд Биеийн тамир, спортын улсын хороо Монголын электрон спортын холбоотой 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр Үндэсний шигшээ багийг электрон спортын наадамд бэлтгэн оролцуулахад улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэрээ байгуулан 2025 оны 10, 12 дугаар сард болох 2 удаагийн арга хэмжээнд нийт 60 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэхээр тогтоод байна. Түүнчлэн Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/67, мөн оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн А/109 дүгээр тушаалаар баталгаажуулан Засгийн газрын 2021 оны “Үндэсний шигшээ багийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 156 дугаар тогтоолын³ дагуу цалинжуулахаар тусгасан.

² <https://sport.gov.mn/n/7244/> Биеийн тамир, спортын улсын хороо

³ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16207241816751>

Аливаа салбарыг ялангуяа спортын аль нэг төрлийг хөгжүүлэхэд зөвхөн төсвийн хөрөнгө оруулалт, төрийн дэмжлэгт тулгуурлах бус хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар дэмжих боломж олгох, оновчтой тогтолцоог бүрдүүлэх нь чухал. Ингэснээр үндэсний аж ахуйн нэгжийн энэ төрлийн спортод хөрөнгө оруулах, аливаа төрлийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах боломжийг бүрдүүлэх, мэргэжлийн тамирчинг бэлтгэх, энэ чиглэлийн маркетингийн тогтолцоог хөгжүүлэх боломжтой байдаг.

Түүнчлэн хувийн хэвшлийн байгууллага өөрийн санаачлага, өөрийн хөрөнгөөр нийгмийн хариуцлагын хүрээнд бодитой хөрөнгө оруулалт оруулах, төсөл хэрэгжүүлэхэд татварын хөнгөлөлт эдэлж нийгэмдээ хувь нэмрээ оруулах идэвх санаачлагыг дэмжин урамшуулж эдийн засаг, нийгмийн хөгжил эерэг нөлөө үзүүлэх, төсвийн ачааллыг бууруулах чухал ач холбогдолтой.

Компанийн нийгмийн хариуцлага буюу Corporate Social Responsibility (CSR)-ийг Монголд хөгжүүлэхийн тулд МҮХАҮТ-аас тодорхой үйл ажиллагааг зохион байгуулж, холбогдох судалгааг явуулдаг байна. Тус байгууллагын энэ оны зургадугаар сард гаргасан 256 компани, хувь хүн оролцуулсан судалгаагаар тэдний зүгээс хамтран ажиллагсад, түншдээ чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлэх нь чухал хэмээн 33.3 нь үзсэн бол 16.6 хувь нь хэрэглэгчдэдээ чиглэсэн арга хэмжээ авах ёстой гэж хариулсан байна.

Нийгмийн аль салбарыг илүү анхаарч буй нь тухайн улсын нийгэм, эдийн засгийн хөгжлөөс шууд хамаардаг. Томоохон бизнесийн байгууллага, компаниуд нийгмийн хариуцлага буюу тогтвортой хөгжлийн талаарх тайлангаа тогтмол мэдээлж байна. Ингэснээр тэдний нэр хүнд, орлого ч өсөж байна. Манай компаниудын 66.6 хувь буюу үүнтэй ижил төстэй тайлан гаргадаг. Энэ нь хоёр жилийн өмнөхөөс хоёр дахин их үзүүлэлт юм. Өөрөөр хэлбэл, Монголын аж ахуйн нэгжүүд нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх сонирхолтой байгааг эндээс харж болохоор байна

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9 дэх хэсэгт албан татвар төлөгчийн орлого олох үйл ажиллагаатай хамааралгүй зарим үйл ажиллагааг нийгмийн хариуцлагын хүрээнд дэмжих зорилгоор элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалт, харилцан хамааралгүй бусад этгээдэд олгосон санхүүгийн дэмжлэг, хандивын зардлыг тус хуулийн 20.1-д заасны дагуу ногдуулсан албан татвараас хасаж хөнгөлөхөөр заасан бөгөөд үүнд спортын барилга байгууламж барьж байгуулах, ашиглах, олимпын төрлийн тэмцээн зохион байгуулах, Монголын үндэсний олимпын хороо, Монголын үндэсний паралимпын хорооны бүртгэлтэй олимпын төрлийн спортын холбоо, түүнд бүртгэлтэй баг, мэргэжлийн тамирчин, дасгалжуулагчид олгосон санхүүгийн дэмжлэг хамаарахаар заасан.

Иймээс Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9.3 заалтад хамааруулахын тул Биеийн тамир, спортын тухай хуульд заасны дагуу бүрдүүлсэн и-спортын үндэсний шигшээ багт үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг хамааруулах замаар шийдвэрлэх боломжтой байна.

ГУРАВ.АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ЭЕРЭГ, СӨРӨГ ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ХАРЬЦУУЛАЛТ

Асуудлуудыг шийдвэрлэх хувилбаруудыг тус бүрээр авч үзвэл:

Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
“Тэг” хувилбар	Асуудал шийдвэрлэгдэхгүй	зорилгод хүрэх боломжгүй
Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх	Асуудлыг шийдвэрлэхтэй холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй. Зардал, үр өгөөж тооцох боломжгүй	зорилгод хүрэх боломжгүй
Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх	Асуудлыг шийдвэрлэхтэй холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй. Зардал, үр өгөөж тооцох боломжгүй	зорилгод хүрэх боломжгүй
Төрөөс санхүүгийн Интервенц хийх	Асуудлыг шийдвэрлэхтэй холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй. Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	зорилгод хүрэх боломжгүй
Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүрэг гүйцэтгүүлэх	Асуудлыг шийдвэрлэхтэй холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй. Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	зорилгод хүрэх боломжгүй
Захиргааны шийдвэр гаргах	Харьяат болгох асуудлыг зөвхөн хуулиар зохицуулах тул боломжгүй	зорилгод хүрэх боломжгүй
Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Холбогдох хуульд тусгайлан зохицуулалт нэмж тусгасны үндсэн дээр шийдвэрлэгдэх боломж бүрдэнэ.	Үр дүнтэй

Дээрх хувилбаруудыг харьцуулан үзэхэд “тэг” хувилбар буюу ямар нэг арга хэмжээг авахгүй байх, одоо байгаа нөхцөл байдлыг хэвээр үлдээх нь шинэ төрлийн спортын хөгжил, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд ахиц дэвшил гарах боломжийг бүрдүүлэхгүй бөгөөд асуудлыг шийдвэрлэхийг зорьсон зорилгод чиглэгдэхгүй байна.

Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх, зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх, төрөөс санхүүгийн интервенц хийх, төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх зэрэг арга хэмжээ буюу тухайлбал, одоогийн хүчин төгөлдөр дагаж мөрдөж буй хууль эрх зүйн баримт бичгийн хүрээнд тодорхой арга хэмжээ авч болох ч зорилгод хүрэх боломж хязгаарлагдмал хэвээр байхаар байна.

Хувийн хэвшил нийгмийн хариуцлагын хүрээнд байгалийн нөөцийг хамгаалах, нэмэгдүүлэх, зохистой ашиглах, цөлжилтийг сааруулах, орчны бохирдлыг бууруулах, соёлын өвийг хамгаалах, сэргээх, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн асрамж хамгааллын үйл ажиллагаа явуулах, боловсрол, шинжлэх ухаан, биеийн тамир, спортыг дэмжих чиглэлээр санхүүгийн дэмжлэг үзүүлсэн аж ахуйн нэгжийг төр татварын бодлогоороо дэмжих агуулга бүхий хуулийн өөрчлөлтийг Улсын Их Хурлаас 2024 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар батлан хэрэгжүүлж байна.⁴

Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “...татварыг зөвхөн Улсын Их Хурал татварын хуулиар бий болгох, тогтоох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй.” гэж заасан.

Иймд аргачлалд заасан хувилбаруудыг хэрэглэх боломжгүй бөгөөд зөвхөн хуулийн төсөл боловсруулах замаар шийдвэрлэх боломжтой юм.

ДӨРӨВ.СОНГОСОН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Монгол Улсын Их Хурлаас 2024 онд баталсан Биеийн тамир, спортын тухай /шинэчилсэн найруулга/ хуульд спортын хөгжил, хөрөнгө оруулалтыг дэмжих агуулга бүхий дэвшилттэй зохицуулалтууд тусгагдсан байдаг. Тус хуультай хамт Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуульд нэмэлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг тус тус батлан спортын хөгжлийг татварын бодлогоор дэмжих агуулга бүхий зохицуулалтыг батлан хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны бодлогын 3.5.13-т Биеийн тамир, спортын нэн шаардлагатай болон тэргүүлэх чиглэл, мэргэжлээр хүний нөөц бэлтгэх арга хэмжээг хэрэгжүүлэхээр, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.4.2-т “Спортын сургалт, дасгалжуулалтыг сайжруулж, үндэсний шигшээ багийн нөөц тамирчдыг бэлтгэн, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн болон олимпын наадамд

⁴ 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулгаас <https://d.parliament.mn/tusul/b4fa6738-18dd-4ff3-aa74-1b5e7fad75b2>

гаргасан амжилтыг хадгалж, Азийн наадамд улсын дүнгээр эхний 15 байрт орох алхмыг үе шаттайгаар хэрэгжүүлэх зорилтыг тус тус тусгасан байдаг.

Спортын салбарынхан, дэмжигчид төрөөс спортыг мэргэжлийн болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх, төрөөс зарим спортын төрөл сонгон авч хөгжлийн загвар гаргах, шинэ тутам хөгжиж байгаа спортын төрлүүдийг бодлогын түвшинд дэмжих, ирээдүйд олимпод орох боломжтой спортын төрлийг одоогоос дэмжих саналуудыг гаргасаар иржээ.⁵

Ийнхүү “спортод өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хүний нөөцийг бэлтгэх, спортын олон төрлийг хөгжүүлэх оновчтой тогтолцоог бүрдүүлэх” зорилгоор шинэ спортын шинэ төрлийг хөгжүүлэх, ялангуяа дэлхий дахин хурдацтай хөгжиж байгаа, манай улсын тамирчин залуус өндөр амжилт үзүүлж байгаа төрлийн спортыг дэмжих зорилгоор и-спортод үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулиар тогтоосон спортын чиглэлээр татварын хөнгөлөлтөд нэмж хамруулахаар тусгах нь зүйтэй.

Хуулийн төсөлд тусгах зохицуулалтыг хүний эрхийг хязгаарласан, сөрөг нөлөө үзүүлэх агуулга байхгүй байхаар боловсруулах боломжтой. Мөн Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд нийцэх бөгөөд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бусад хууль тогтоомжтой зөрчилдөхгүй болно.

Зарим орнуудад тогтмол, мэргэжлийн түвшний тэмцээнээс бусад, сонирхогчийн түвшний тэмцээний шагналыг татвараас чөлөөлдөг. (Тухайлбал, UAE, Monaco) албан татвар байхгүй тул бүх төрлийн шагналын орлого нь татваргүй. Канад, Сингапур, Франц, Швед зэрэг орнууд нь тоглоом хөгжүүлдэг компаниудад татварын хөнгөлөлт үзүүлдэг. Өмнөд Солонгос улсад нийслэлийн бус нутаг дэвсгэрт цахим спортын арга хэмжээ зохион байгуулдаг болон e-sport-ын багийг ажиллуулдаг дотоодын компаниуд 2025 оны 1-р сарын 1-ээс 2026 оны 12-р сарын 31-ний хооронд болох цахим спортын арга хэмжээнд шууд гарсан үйл ажиллагааны зардлын 10 хувийн татварын хөнгөлөлт эдлэх боломжтой (цалин, ирцийн хураамж, сургалтын тоног төхөөрөмж гэх мэт).

Франц улс 2016 онд Дижитал Бүгд Найрамдах Улсын тухай хууль баталж (Loi pour une République numérique) шинэ зохицуулалттай болсон. Ингэснээр e-sport-г хууль ёсоор спортын нэг төрөл хэмээн хүлээн зөвшөөрсөн анхны Европын улс бөгөөд тоглогчдыг “мэргэжлийн тамирчин” гэсэн статустай болж тоглогчдын гэрээ, тэмцээний орлого, ажлын цагийн зохицуулалт илүү тодорхой болсон. Мөн шууд татварын хөнгөлөлт гэхээсээ илүү, тогтвортой эрх зүйн болон нийгмийн хамгаалалтын орчин бүрдүүлсэн. Мэргэжлийн тоглогчийн гэрээг бусад тамирчдын

⁵ Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлгийн талаарх саналын товъёг.2024 он. <https://lawforum.parliament.mn/project/581/>

гэрээний нэгэн адил хууль ёсоор хүлээн зөвшөөрч, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн хамгааллын нөхцөлийг бүрдүүлсэн. Жилийн 5 мянган евро хүртэлх мэргэжлийн бус тоглогчийг шагналын орлогын албан татвараас чөлөөлдөг нь шинэ тоглогчийг тэмцээнд оролцох боломжийг нэмэгдүүлж, салбарын хөгжлийг дэмждэг байна. Esport-ын баг ажилуулдаг эсвэл тоглоом хөгжүүлдэг компаниуд зарим зардлыг (тоглогчдын цалин, сургалтын төлбөр, аялалын зардал гэх мэт) бизнесийн зардал болгон тайлагнаж болно. Эдгээр зардал нь компанийн татвар ногдох орлогыг бууруулдаг тул компани аж ахуйн нэгжийн албан татварыг бага дүнгээр төлдөг. Тоглоом эсвэл платформ бүтээдэг компаниудын хөгжүүлэлтийн зардлын 30 хувийг буцаан олгодог. Энэ чиглэлээр Дижитал хөгжлийн яам, Спортын яам хамтран ажиллаж, салбарын хөгжилд дэмжлэг үзүүлж байна.

ДҮГНЭЛТ

Төрөөс спортыг мэргэжлийн болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх, зарим спортын төрөл сонгон авч хөгжлийн загвар гаргах, шинэ тутам хөгжиж байгаа спортын төрлүүдийг бодлогын түвшинд дэмжих, ирээдүйд олимпод орох боломжтой спортын төрлийг одоогоос дэмжих шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Аливаа салбарыг ялангуяа спортын аль нэг төрлийг хөгжүүлэхэд зөвхөн төсвийн хөрөнгө оруулалт, төрийн дэмжлэгт тулгуурлах бус хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар дэмжих боломж олгох, оновчтой тогтолцоог бүрдүүлэх нь чухал. Ингэснээр үндэсний аж ахуйн нэгжийн энэ төрлийн спортод хөрөнгө оруулах, аливаа төрлийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах боломжийг бүрдүүлэх, мэргэжлийн тамирчинг бэлтгэх, энэ чиглэлийн маркетингийн тогтолцоог хөгжүүлэх боломжтой байдаг.

Түүнчлэн хувийн хэвшлийн байгууллага өөрийн санаачлага, өөрийн хөрөнгөөр нийгмийн хариуцлагын хүрээнд бодитой хөрөнгө оруулалт оруулах, төсөл хэрэгжүүлэхэд татварын хөнгөлөлт эдэлж нийгэмдээ хувь нэмрээ оруулах идэвх санаачлагыг дэмжин урамшуулж эдийн засаг, нийгмийн хөгжил эерэг нөлөө үзүүлэх, төсвийн ачааллыг бууруулах чухал ач холбогдолтой.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9 дэх хэсэгт албан татвар төлөгчийн орлого олох үйл ажиллагаатай зарим үйл ажиллагааг нийгмийн хариуцлагын хүрээнд дэмжих зорилгоор элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалт, харилцан хамааралгүй бусад этгээдэд олгосон санхүүгийн дэмжлэг, хандивын зардлыг тус хуулийн 20.1-д заасны дагуу ногдуулсан албан татвараас хасаж хөнгөлөх зохицуулалттай бөгөөд уг зохицуулалтад спортын барилга байгууламж барьж байгуулах, ашиглах, олимпын төрлийн тэмцээн зохион байгуулах, Монголын үндэсний олимпын хороо, Монголын үндэсний паралимпын хорооны бүртгэлтэй олимпын төрлийн спортын холбоо, түүнд бүртгэлтэй баг, мэргэжлийн тамирчин, дасгалжуулагчид олгосон санхүүгийн дэмжлэг хамаардаг.

Ийнхүү манай улсын хууль тогтоомжоор тогтоосон урамшуулал, дэмжлэг хөнгөлөлт чөлөөлөлт зөвхөн олимпын төрөлд хамаарах спорт, эсхүл үндэсний спортыг дэмжих агуулгатай байдаг. Шинэ тутамд эрчимтэй хөгжиж байгаа, ирээдүйд амжилт үзүүлэх боломжтой гэж үзэж болох и-спортын төрөл нь олимпын төрөлд хараахан багтаагүй байх тул татварын хөнгөлөлтөд хамрагдахааргүй байдаг.

Иймд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дээрх заалтад и-спортын үндэсний шигшээ багийн мэргэжлийн тамирчин, дасгалжуулагчид олгосон санхүүгийн дэмжлэг хамаарах агуулгыг нэмэхээр хуулийн төсөл боловсруулах замаар спортын олон төрлийг хөгжүүлэх, ялангуяа шинэ тутам гарч ирж буй спортыг хөгжүүлэх, технологийн хөгжилд суурилсан оюуны спортыг татварын бодлогоор дэмжих боломж бүрдэхээр байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “... татварыг зөвхөн Улсын Их Хурал татварын хуулиар бий болгох, тогтоох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй.” гэж заасанд нийцнэ.

---o0o---

Хавсралт

Хууль, эрх зүйн акт нэр	Холбогдох зохицуулалт
Биеийн тамир, спортын тухай хууль 2025.06.05	10.1.Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 10.1.1.улсын төсөв болон Спортыг дэмжих сангаас дэмжлэг үзүүлэх спортын төрөл ангиллыг сонгох, үндэсний шигшээ багийг бүрдүүлэх; 23 дугаар зүйл.Үндэсний шигшээ баг 23.1.Үндэсний шигшээ баг өсвөр үе, залуучууд, оюутны, насанд хүрэгчдийн гэсэн ангилалтай байна. 23.2.Бие даасан бүтэцтэй байгуулах үндэсний шигшээ багийг тухайн спортын төрлийн холбооноос санал авсны үндсэн дээр бүрдүүлж, зохион байгуулна. 23.3.Монгол Улсын нэрийн өмнөөс олон улс, тив, дэлхийн спортын тэмцээн, наадамд оролцох үндэсний шигшээ багийг спортын холбоо бүрдүүлж, үйл ажиллагааг нь хариуцан зохион байгуулна. 23.4.Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага Захиргааны ерөнхий хууль болон энэ хуулийн 10.1.1-д заасан журмын дагуу сонгосон спортын төрлийн холбоотой гэрээ байгуулж, санхүүжүүлнэ. 23.5.Аймаг, дүүргийн Засаг дарга спортын 10-аас доошгүй төрлөөр өсвөр үеийн шигшээ багийг байгуулан, орон нутаг дахь спортын холбоотой хамтран сонгон шалгаруулж, орон нутгийн төсвөөс үйл ажиллагааг санхүүжүүлнэ. 23.6.Нийслэлийн Засаг дарга оюутны дэлхийн аварга, дэлхийн оюутны спортын наадамд Монгол Улсыг төлөөлөн оролцох оюутны шигшээ багийг спортын 8-аас доошгүй төрлөөр байгуулж, санхүүжүүлнэ. 23.7.Спортын онцгой авьяас, чадвартай суралцагч, оюутан, залуучуудыг илрүүлэх, спортын сургуульд суралцах нөхцөл бололцоогоор хангах, тухайн сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах, үндэсний шигшээ багийн тамирчдын нөөцийг бэлтгэнэ. 23.8.Ёс зүйн болон допингийн зөрчил гаргасан нь шигшээ багийг бүрдүүлж байгаа спортын холбоо, тамирчин, дасгалжуулагчийг санхүүжүүлэхгүй байх үндэслэл болно. 34 дүгээр зүйл.Биеийн тамир, спортын санхүүжилт 34.1.Энэ хуулийн 9.1.2, 9.1.4, 10.1.2, 23.4, 23.6, 28.1, 36.2-т заасан үйл ажиллагааг улсын төсвөөс, 22.3-т заасныг Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан Спортыг дэмжих сангаас санхүүжүүлнэ. 34.2.Энэ хуулийн 12.1.1, 12.1.3, 12.1.4, 13.1.5, 13.1.7, 13.1.8-д заасан үйл ажиллагааг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ. 34.3.Биеийн тамир, спортын байгууллага санхүүгийн эх үүсвэрээ нэмэгдүүлэх, ажилтан, дасгалжуулагч, тамирчны нийгмийн баталгааг дээшлүүлэх зорилгоор хууль тогтоомжид нийцүүлэн ажил, үйлчилгээ явуулж болох бөгөөд түүнээс олсон орлогоо энэ хуульд заасан зориулалтын дагуу захиран зарцуулж болно. 34.4.Энэ хуулийн 10.1.7-д заасан журмын дагуу орон нутгийн биеийн тамир, спортын байгууллага хууль тогтоомжид нийцүүлэн нэмэлт болон төлбөртэй үйлчилгээ үзүүлж, олсон орлогыг биеийн тамир, спортын ажилтны хөдөлмөрлөх нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах, тоног төхөөрөмж худалдан авах, засвар үйлчилгээ хийхэд зарцуулж болно. 34.5.Биеийн тамир, спортын байгууллагын өөрийн орлогын хэмжээтэй холбоотойгоор улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийн хэмжээг багасгахыг хориглоно. 34.6.Биеийн тамир, спортын зардлыг улсын болон орон нутгийн төсөвт бие даасан зүйл болгон баталж, төсвөөс санхүүжүүлнэ.

	34.7.Биеийн тамир, спортод зориулсан төсвийн болон сангийн хөрөнгийг өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.
Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль	22.9.Албан татвар төлөгчийн орлого олох үйл ажиллагаатай хамааралгүй доор дурдсан үйл ажиллагааг нийгмийн хариуцлагын хүрээнд дэмжих зорилгоор элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалт, харилцан хамааралгүй бусад этгээдэд олгосон санхүүгийн дэмжлэг, хандивын зардлыг энэ хуулийн 20.1-д заасны дагуу ногдуулсан албан татвараас хасаж хөнгөлнө. Хөнгөлөх дүн нь тухайн татварын жилийн татвар ногдох орлогын 1 хувь хүртэл хэмжээнээс хэтрэхгүй байна: 22.9.6.спортын барилга байгууламж барьж байгуулах, ашиглах, олимпын төрлийн тэмцээн зохион байгуулах, Монголын үндэсний олимпын хороо, Монголын үндэсний паралимпын хорооны бүртгэлтэй олимпын төрлийн спортын холбоо, түүнд бүртгэлтэй баг, мэргэжлийн тамирчин, дасгалжуулагчид олгосон санхүүгийн дэмжлэг;
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль	7.4.Иргэдэд үйлчлэх спортын зориулалттай барилга байгууламжийг үл хөдлөх эд хөрөнгийн албан татвараас эхний 5 жилд 100 хувиар хөнгөлнө.
Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль	40.10.Олон улсын спортын холбооны стандартад нийцсэн, олимп, тив дэлхийн тэмцээн зохион байгуулах шаардлага хангасан спортын барилга байгууламжийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулах тоног төхөөрөмж, спортын зориулалт бүхий барилгын материалын гаалийн албан татварын төлөх хугацааг 4 жил хүртэл хугацаагаар сунгах, эсхүл уг татварыг 4 жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэх шийдвэрийг Засгийн газар гаргаж болно.
Засгийн газрын тусгай сангийн тухай хууль	14 дүгээр зүйл. Спортыг дэмжих сан 14.1.Спортыг дэмжих сан нь нийтийн биеийн тамир, хүн амын идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэсэн иргэний үр дүнг харгалзан магадлан итгэмжлэгдсэн спортын клубт үйлчилгээний төлбөрийн дэмжлэг үзүүлэх,, өндөр зэрэглэлийн тамирчин, дасгалжуулагчийг шинжлэх ухааны үндэслэлтэй бэлтгэх, үндэсний спортын төрлийг хөгжүүлэх, үндэсний хэмжээний тэмцээн, наадмын сэргээшийн эсрэг хяналтыг хэрэгжүүлэх, сэргээшийн эсрэг үйл ажиллагааны сургалт, сурталчилгааг зохион байгуулах, биеийн тамир, спортын чиглэлээр судалгаа, шинжилгээ хийх зориулалттай байна. 14.2.Спортыг дэмжих сангийн хөрөнгө нь энэ хуулийн 6.1.2, 6.1.3, 6.2.2-т заасан эх үүсвэрээс бүрдэнэ. 14.3.Спортыг дэмжих сангийн хөрөнгийг энэ хуулийн 14.1-д заасан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна. 14.4.Спортыг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, хяналт тавих журмыг Засгийн газар батална.
Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай	32.3.Энэ хуулийн 21.2.1, 21.2.3, 21.3.1, 21.3.7, 22.5-д заасан гадаад ажилтан, боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, соёл, спортын байгууллагад гэрээгээр ажиллах эмч, эрдэм шинжилгээний ажилтан, мэргэжлийн багш, дасгалжуулагч авч ажиллуулах ажил олгогчийг ажлын байрны төлбөрөөс чөлөөлнө. /21.3.7.соёл, спортын байгууллагад ажиллах мэргэжлийн багш, дасгалжуулагч, мэргэжилтэн./
Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын тушаал 2025.05.07.А/75	ААНОАТТ хуулийн 22.9.6-д заасан "спортын барилга байгууламж барьж байгуулах, ашиглах, олимпын төрлийн тэмцээн зохион байгуулах, Монголын үндэсний олимпын хороо, Монголын үндэсний паралимпын хорооны бүртгэлтэй олимпын төрлийн спортын холбоо, түүнд бүртгэлтэй баг, мэргэжлийн тамирчин, дасгалжуулагчид олгосон

	санхүүгийн дэмжлэг" хүрээнд албан татварын хөнгөлөлтөд хамрагдах бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага
--	---

Хавсралт

Дэлхийн esports-ийн байгууллагууд

Улс	Байгууллага	Тайлбар
ОХУ	RESF (Russian Esports Federation)	2016 оноос спортын холбоо гэж бүртгэгдсэн, Спортын яамны харьяа.
Финлянд	SEUL	Финландын Олимпын хороонд албан ёсоор бүртгэлтэй.
Өмнөд Солонгос	KeSPA	Соёл, спорт, аялал жуулчлалын яамны дэргэд ажилладаг.
Хятад	CNEA	Спортын ерөнхий газрын харьяа, төрийн хатуу зохицуулалттай.
Сингапур	SGEA	Sport Singapore-ийн харьяа Үндэсний спортын холбоо.
Филиппин	PESO	Филиппиний Олимпын хорооноос баталгаажсан NSA.
Вьетнам	VIRESA	Соёл, спорт, аялал жуулчлалын яамны харьяа.
Энэтхэг	ESFI	2022 онд Засгийн газар esports-ийг спорт болгон хүлээн зөвшөөрсөн.
Саудын Араб	SEF (Saudi Esports Federation)	Спортын яамны харьяа, Vision 2030 стратегийн хэсэг.
АНЭУ	Emirates Esports Federation	Засгийн газраар албан ёсоор хүлээн зөвшөөрсөн.
Турк	TESFED	Залуучууд, спортын яамны харьяа.
Индонез	IESPA	Индонезийн Спортын яамны албан ёсны холбоо.
Малайз	MESF	Залуучууд, спортын яамны дэмжлэгтэй.

Тайланд	TESF	Тайландын Спортын газарт бүртгэлтэй.
Өмнөд Африк	MSSA (Mind Sports South Africa)	Улсын спортын холбооны бүрэлдэхүүнд ордог.